



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/205

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Ж.Наранцацралт-1-103 тоот)-д байршилтай иргэн Төмөрбатын Эрдэнэбаатар (ЗЮ:74050214)-ын худалдаа, үйлчилгээний зориулалттай 290 м.кв (0,02га) газрыг иргэн Оргодолын Эрдэнэбаяр (ЗЮ:76021331)-т зориулалтаар нь шилжүүлж 14 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, бөгөөд Мандалговь хотын захирагч (С.Бат-Оргил) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/217 дугаар захирамжийн иргэн Т.Эрдэнэбаатар-т холбогдох хэсэг мөн газар эзэмших 000025646 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100786